

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, түүний гүйцэтгэл	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Зорилтот түвшин, түүний гүйцэтгэл	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ЭХЗХ	Эрчим Хүчний Зохицуулах Хороо
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ОСНААУГ	Орон Сууц Нийтийн Аж Ахуйг Удирдах Газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАЯРСАЙХАН
ТАНАА

2020.03.13 № 06/779
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Баярсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цаашид өр төлбөрийг барагдуулах талаар ажиллах, үндсэн хөрөнгө бэлтгэхдээ холбогдох хууль, заавар журмын дагуу шийдвэрлүүлэх, зардлын дансны ангиллыг зөв ангилж тайлагнах, ашиглалтын хугацаа дууссан биет бус хөрөнгийг холбогдох хууль, заавар журмын дагуу шийдвэрлүүлэх, үргүй зардал гаргахгүй байх, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмыг мөрдөж ажиллах, бүртгэл тайлагнал, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах талаар Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон Улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК санхүүгийн тайлан, тодруулга тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 18-с 2020 оны 03 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн гүйцэтгэх захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Баянсуварга Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК нь 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга тайланг Баянсуварга Аудит ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 03/192 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Дулааны эрчим хүчийг хамгийн бага зардлаар найдвартай түгээж, борлуулж, хэрэглэгчдэд хүнд сурталгүй үйлчилнэ” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийслэл хотын төвлөрсөн дулаанд холбогдсон хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах, түгээх, шугам тоноглолын засвар үйлчилгээг чанартай хийж үйлдвэрлэлийг найдвартай явуулах,
- Тооцоо судалгааг үндэслэн шинэ барилгуудыг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох
- Дулааны эх үүсвэрт боловсруулсан дулааны эрчим хүчний чанарт байнгын хяналт тавьж алдагдалгүй дамжуулах,
- Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд бие даасан эх үүсвэртэй барилга байгууламжийг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох, тооцоо судалгаа хийж хэрэгжүүлэх
- Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн дулааны сүлжээний гидравлик тооцоог боловсруулж, горимын оновчтой хувилбар хэрэгжүүлэх
- Эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу өсөн нэмэгдэх хэрэглээг хангах төсөл хөтөлбөр боловсруулах, дулааны тоолуур, хянах хэмжих хэрэгсэл суурилуулах баталгаажуулах, хэрэглэгчдэд мэргэжил арга зүйн зөвлөмж, туслалцаа үзүүлэх зэрэг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЭХЗХ-ны 2019 оны 18, 19, 23, 45 дугаар тогтоолоор станцуудын дулааны эрчим хүч худалдан авах тариф
- ЭХЗХ-ны 2019 оны 123 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын хэрэглэгчдэд борлуулах дулаан, уурын тариф

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Интерактив Би Ай компанийн боловсруулсан “Diamond, Payroll” программ хангамж ашигладаг байна.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд сайн гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 17 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт орлогыг суурь болгон сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 96,357.8 сая төгрөгөөс тооцон 1,927.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан..

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 2 хувиар тооцон 2,052.6 сая төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн шатанд үе шатанд тайлант оны суурь үзүүлэлтийн дүнгээс материаллаг байдлын түвшнийг тооцсон тул мөнгөн дүнгийн хувьд өөрчлөлт орсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,338.0 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	1,009.8	877.4	(132.4)
Авлага	6,384.2	5,377.7	(1,006.6)
Урьдчилгаа	121.0	43.9	(77.1)
Бараа материал	639.8	723.4	83.5
Үндсэн хөрөнгө	195,853.8	206,922.4	11,068.6
Урт хугацаат хөрөнгө оруулалт	13,448.1	12,470.1	(978.0)
Хойшлогдсон татварын хөрөнгө	736.4	1,156.4	419.9
Нийт хөрөнгө	218,233.3	227,571.3	9,338.0
Өр төлбөр	28,299.7	24,564.8	(3,734.8)
Эздийн өмч	189,933.6	203,006.4	13,072.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	218,233.3	227,571.3	9,338.0

Авлага дансны үлдэгдэл 1,006.6 сая төгрөгөөр буурсан нь татварын авлага өмнөх жилээс 872.2 сая төгрөгөөр, дулааны эрчим хүчний авлага 92.8 сая төгрөгөөр, бусад авлага 24.5 сая төгрөгөөр найдваргүй авлагын хасагдуулга 17.1 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

ОСНААУГ-с авах зээл, зээлийн хүүгийн авлага нь 1,545.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь авлагын 28.7 хувийг эзэлж байна. Үүний 1,398.2 сая төгрөгийн

авлага нь Орон сууцны компаниудын 1548 MON(SF) Дулааны үр ашгийн төслийн дамжуулан зээлийн гэрээний дагуу төлөх төлбөр, 147.3 сая төгрөгийн авлага нь 1492 MON(SF) Эрчим хүчний хэмнэлтийн төслийн дамжуулан зээлийн гэрээний дагуу 2019 он хүртэлх хугацаанд төлөх төлбөр бөгөөд гэрээний дагуу Сангийн яаманд төлсөн байна. Авлага барагдуулах талаар ОСНААУГ-т удаа дараа хандсан боловч ЭХЗХ-с үнэ тарифт багтаагүй, төлбөрийн чадвар байхгүй гэсэн шалтгаанаар төлөгдөөгүй өдий хүрсэн байна. Сүүлийн жилүүдэд ЭХЗХ-нд ОСНААУГ-ын зээлийн авлагыг үнэ тарифт багтаах талаар албан тоот хүргүүлсэн ч асуудал шийдэгдээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аюулгүй найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай түлш шатахуун 1,7 сая төгрөг, гамшгийн бэлэн байдлын химийн материал, сэлбэг хэрэгсэл 51,1 сая төгрөг, аюулгүй болон байнгын нөөц 30.7 сая төгрөгийн нөөцийн сэлбэг хэрэгсэл худалдан авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө нь нийт хөрөнгийн 90.0 хувийг эзэлж байна. Өмнөх онуудаас үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь өөрийн хөрөнгөөр 7,672.6 сая төгрөгийн хөрөнгө, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12,935.2 сая төгрөгийн, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 671.2 сая төгрөгийн хөрөнгө, эргэлтийн хөрөнгөөс капиталжуулсан 68.8 сая төгрөг нийт 21,347.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөл, ТӨБЗГ-ын тогтоолуудыг үндэслэн 3,134.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан, ТӨБЗГ-ын 2019 оны 624 дүгээр тогтоолыг үндэслэж 166.8 сая төгрөгийн хөрөнгийг “Дулааны дөрөвдүгээр станц” ТӨҮГ, “Хөвсгөл Дулааны станц” ТӨҮГ-т балансасан балансанд шилжүүлсэн, тайлант оны элэгдлийн зардал 9,739.1 сая төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдлийн бууралт 3,263.8 сая төгрөг тус тус тайлагнасан байна.

Биет бус хөрөнгө тайлант оны элэгдлийн зардлаар буурчээ.

Богино хугацаат өр төлбөр буурсан нь тайлант онд худалдан авсан дулааны эрчим хүчний үнэ тарифыг ЭХЗХ-с зохицуулж өгснөөс шалтгаалан өр төлбөр 2,813.6 сая төгрөгөөр буурсан.

Урт хугацаат өр төлбөр нь Сангийн яамтай хийсэн гэрээний дагуу “1492 MON(SF) Эрчим хүчний хэмнэлтийн төслийн дамжуулан зээл”, “1548 MON(SF) Дулааны үр ашгийн төслийн зээлээс тайлант онд 1,504.8 сая төгрөг төлж, оны эцэст 18,633.0 сая төгрөгийн өр байна. Хувийн хэвшлийн хөрөнгөөр шинэчлэгдэн солигдсон шугам хоолойг бүртгэн авч, эх үүсвэрийг хойшлогдсон орлого дансанд бүртгэснээр 583.6 сая төгрөгөөр урт хугацаат өр төлбөр нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт урт хугацаат өр төлбөр нь 921.2 сая төгрөгөөр буурсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 203,006.4 сая төгрөг болж 13,072.8 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгөөр оруулалтаар хийсэн дулааны шугамын ажил, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор компанийн эздийн өмчийг 41,444.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, ашигтай ажилласан зэргээс шалтгаалсан байна.

2.9. Зорилтот түвшин, түүний гүйцэтгэл

ЭХЯ-с Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд борлуулалтын орлогыг 98,056.7 сая төгрөг, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 76,419.9 сая төгрөг, удирдлагын зардлыг 28,476.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны алдагдлыг 6,839.2 сая төгрөг байхаар тус тус баталсан байна.

Тайлант онд гүйцэтгэлээр 102,628.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 102,377.7 сая төгрөгийн зардал гарган 250.4 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллаж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардалд 112.8 сая төгрөг төлөхөөр гарч 137.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Борлуулалтын орлого 4,321.0 сая төгрөгөөр давж биелсэн нь дулаан хангамжид шинээр холбогдсон 204.3 Гкал/цагийн ачаалал бүхий 351 хэрэглэгчийн барилга байгууламжийн эх үүсвэрийн өөрчлөлт, ЭХЗХ-ны 2019 оны 123 дугаар тогтоолоор батлагдсан хэрэглэгчдэд худалдан борлуулах дулааны эрчим хүчний тарифыг 10 хувиар нэмэгдүүлж 2019 оны 6 дугаар сараас эхлэн мөрдөж эхэлсэн зэргээс шалтгаалсан байна

Зорилтот түвшний зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэл:

- Урсгал засварын зардал 137.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Сэлбэг хэрэгсэл, урсгал засварын материалын зардлуудад худалдан авалтын үнийн дүнгийн хэмнэлт гарсан, давтамж хувьсгуурын сэнсийг насос станц №3 дээр тавихаар төлөвлөсөн байсан боловч хуучин агааржуулалтын систем хоолойн нэвтрэх чадварыг ихэсгэж агааржуулалтыг сайжруулсан тул тус ажлыг хойшлуулсан, сүүлийн жилүүдэд гэмтэл ихээр гарч байгаа 7г, 8а, 2в магистрал шугамаас хангагддаг хэрэглэгчдийн тоо хотын төвд байрлалтай Засгийн газрын байр, Элчин сайдын яам, Тамгын газар, эмнэлэг, сургууль цэцэрлэг зэрэг 1 дүгээр шатлалын хэрэглэгчдийг хангадаг шугамууд дээр гэмтэл гарсан үед гэмтэлтэй хэсгийг тусгаарлан авч үлдээд бусад хэрэглэгчдийг хэвийн хангахын тулд шаардлагатай засварын материалыг бэлэн байлгахаар төлөвлөсөн зэргээс шалтгаалсан байна.

- Гүйцэтгэх удирдлагын зардал 72.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Удирдлагын томилолт, сургалтын зардлыг гаргаагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлбөрт төлөх мөнгийг хуулийн дагуу нэг жил завсарласан зэрэг шалтгаалжээ.

- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 29 дүгээр тогтоол, 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 288 дугаар тогтоолуудаар ДҮТ-ийн 2019 оны диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний төлбөрийг шинэчлэн баталсантай холбоотой 162.8 сая төгрөгөөр, мөн 2019 оны 29 дүгээр тогтоолоор ЭХЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хураамжийг шинэчлэн баталсантай холбоотойгоор 4.7 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

- Элэгдлийн зардал 80.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь үлдэгдэл өртөгтэй актлагдах дулааны шугам хоолойн актлах тогтоол шийдвэр хойшилж, уг хөрөнгө бүртгэлээс хасагдаагүйтэй холбоотой.

- Ажиллагсдын нийгмийн зардалд төлөвлөгдсөн хоолны зардлыг хамтын гэрээний дагуу 4 дүгээр улиралд 0.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх байсныг нэг сар хойшлуулж 11 дүгээр сараас нэмэгдүүлсэн, компанийн түүхт 60 жилийн ойн арга хэмжээнд төлөвлөсөн зардлаас ном, альбом хэвлэх ажил хийгдээгүйгээс гадна ажил хөдөлмөрөөрөө тэргүүлсэн ажиллагсдыг эх орны үзэсгэлэнт газраар аялуулах зардлыг хэмнэсэн зэргээс 62.0 сая төгрөг, олон нийт, спортын арга хэмжээний зарим ажлуудыг хойшлуулснаас 48.4 сая төгрөг гэх мэтээр нийт 162.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 17 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,228.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 833.0 сая төгрөгийн алдааг залруулж, 395.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнд:

Санхүүгийн тайлангийн залруулга

- Бараа материалын дансанд 1.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 8.4. “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна” заалттай нийцээгүй, Толилуулга ба илчлэл “аливаа зүйлийг холбогдох санхүүгийн тайлагналын баримтлалын дагуу дэлгэн харуулж, ангилж тодорхойлсон байх” батламж мэдэгдлийг хангаагүй

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд дуусаагүй барилга данснаас капиталжсан барилга байгууламж, шугам хоолойг шилжүүлэн бүртгэх 793.1 сая төгрөгийг худалдан авсан ангилалд бүртгэсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 8.4. “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна” гэж заасантай нийцээгүй, Толилуулга ба илчлэл “аливаа зүйлийг холбогдох санхүүгийн тайлагналын баримтлалын дагуу дэлгэн харуулж, ангилж, тодорхойлсон байх” батламж мэдэгдлийг хангаагүй
- Дараа тайлангаар ажиллагсдад олгосон 38.8 сая төгрөгийн анхан шатны баримт /нисклэгийн тийзийн орох, гарах тасалбар, паспортын хуулбар/ дутуу бүртгэсэн нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй, үнэн ба зөв батламж мэдэгдлийг хангаагүй алдаануудыг залруулав.

Аудитаар 395.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар өр төлбөр, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 6 төрлийн 50 мэдээллээс 46 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 395.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тооцсон 2,052.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлтийг өгч байна.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 зүйлийн 14.1.3-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт: Гүйцэтгэх захирлын 2019 оны 12-р сарын 31-ний Б/325 тоот тушаалаар нэр бүхий дөрвөн ажилтанд орон сууцны зээлд дэмжлэг үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор тооцсон 80,0 сая төгрөг, Гүйцэтгэх захирлын 2019 оны 12-р сарын 23-ний Б/317 тушаалаар нэр бүхий ажилтанд нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгохоор шийдвэрлэж 35.4 сая төгрөг, нийт 115.4 сая төгрөгийг тайлант оны үйл ажиллагааны зардал, өглөг дансаар бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3."Жинхэнэ хэрэгжилтийн зарчим"-тай нийцээгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл: Санхүүгийн тайланд өр төлбөр буруу дүнгээр тусгагдаж, тайлант оны зардал нэмэгдэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3. Өгсөн зөвлөмж: Цаашид компанийн батлагдсан зорилтот түвшний гүйцэтгэлийг тайлант онд хэрэгжүүлж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын заавар журмыг мөрдөж ажиллах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

3.2. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт: ТУЗ-ын 2018 оны "Компанийн 2018 оны их засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай" 34 дүгээр тогтоолоор албан хэрэгцээнд 1, шуурхай ажиллагааны бригадад 2 автомашин худалдан авахад 170.0 сая төгрөг батлагдан 2019 оны 2 дугаар сард дээрх 3 автомашиныг 165.0 сая төгрөгөөр ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй авсан нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолд заасан "Төрийн өмчит хуулийн этгээд тээврийн хэрэгсэл худалдан авах тухай бүр ТӨБЗГ-аас зөвшөөрөл авна. Ийнхүү зөвшөөрөл олгохдоо эрх бүхий байгууллагаас тогтоосон тоо, төрлийг харгалзан үзнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл: Үндсэн хөрөнгө санхүүгийн тайланд бүрэн тусгагдаагүй байх, холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх, бүртгэлээр тавих дотоод хяналт сулрах.

3.2.3. Өгсөн зөвлөмж: Тухайн оны бизнес төлөвлөгөөний дагуу худалдан авалт хийх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас холбогдох зөвшөөрөл авч байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

3.3. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт: Тайлант оны биет бус хөрөнгийн тооллогын тооцоо бодсон актаар 23 нэр төрлийн 822.8 сая төгрөгийн хөрөнгөөс 2000 оны “Зохиогчийн эрх барааны тэмдэг” 34.5 сая төгрөг, 2012 оны “Бар кодын программ” 0.5 сая төгрөг, 2014 оны “Цайны газрын удирдлагын программ” 1.5 сая төгрөг тус тус анхны өртгөө нөхсөн хэрэгцээ шаардлагагүй, ашиглалтгүй программ, биет бус хөрөнгийг данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, хэмжилт, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

3.3.2. Эрсдэл: Хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгээгүй байх, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг бүртгэлээс хасаагүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.3.3. Өгсөн зөвлөмж: Цаашид ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол, заавар журмын дагуу шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

3.4. Зардлын данстай холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт: Тайлант онд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ТЗБАХ-2019/6 гэрээт ажлын төлбөр 29.9 сая төгрөг, Судалгааны ажлын гэрээгээр Зөвлөх үйлчилгээний ЗҮ-2019/04 ажлын санхүүжилт 49.0 сая төгрөг нийт 78.9 сая төгрөгийг үйл ажиллагааны бус зардлын дансанд бичиж тайлагнасан байна. Энэ нь тус компани Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3.10. Зардлын бүртгэлийн бодлого хэсгийн “Үйл ажиллагааны бус зардал”-ын заалттай зөрчилдөж байна

3.4.2. Эрсдэл: Зардал буруу ангилан бүртгэсэн байх, дансны бичилт буруу хийсэн байх, баримтын бүрдүүлэлгүй орлого, зарлага хүлээн зөвшөөрсөн байх

3.4.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Сангийн сайдын 7 дугаар тушаалыг мөрдөж ажиллах, үр ашиггүй зардал гаргахгүй талаар анхаарч ажиллах.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,009,805,060.97	877,358,499.26
1.1.2	Дансны авлага	3,486,984,543.56	3,377,041,270.03
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,022,920,804.68	150,762,152.21
1.1.4	Бусад авлага	1,874,344,902.90	1,849,876,586.21
1.1.5	Бараа материал	639,848,937.37	723,435,104.64
1.1.6	Урьдчилж төлсөн зардал тооцоо	121,004,729.44	43,943,816.44
1.1.7	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,154,908,978.92	7,022,417,428.79
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	193,729,774,362.57	204,842,086,607.24
1.2.2	Биет бус хөрөнгө	2,124,050,975.64	2,080,337,754.40
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	13,488,103,381.81	12,470,065,623.07
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	736,448,822.26	1,156,391,509.84
1.2.7	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	210,078,377,542.28	220,548,881,494.55
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	218,233,286,521.20	227,571,298,923.34
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.2	Дансны өглөг	5,797,337,127.39	2,917,326,237.68
2.1.3	Татварын өр	5,644,371.00	-
2.1.4	Урьдчилж орсон орлого	211,164,333.13	287,507,848.37
2.1.5	Бусад богино хугацаат өр төлбөр	275,198,687.00	270,925,870.00
2.2	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,289,344,518.52	3,475,759,956.05
2.1.3	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.4	Урт хугацаат зээл	20,137,819,521.07	18,633,010,018.07
2.1.5	Бусад урт хугацаат өр төлбөр	1,872,506,845.26	2,456,089,054.56
2.1.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	22,010,326,366.33	21,089,099,072.63
2.2	Өр төлбөрийн нийт дүн	28,299,670,884.85	24,564,859,028.68
2.3.1	Төрийн өмч	133,086,185,117.05	174,531,041,480.35
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,227,515,025.53	18,810,123,237.03
2.3.3	Төсвийн санхүүжилт	41,445,006,176.41	12,935,393,142.11
2.3.4	Эздийн өмчийн бусад хэсэг	2,051,204,420.00	2,051,204,420.00
2.3.5	Хуримтлагдсан ашиг	(5,876,295,102.64)	(5,321,322,384.83)
2.3.6	Эздийн өмчийн дүн	189,933,615,636.35	203,006,439,894.66
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	218,233,286,521.20	227,571,298,923.34

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	95,061,167,931.97	101,631,521,737.71
2	Борлуулалтын өртөг	77,614,372,156.10	74,855,126,896.00
3	Нийт ашиг (алдагдал)	17,446,795,775.87	26,776,394,841.71
5	Хүүгийн орлого	327,002,132.98	136,891,546.96
8	Бусад орлого	969,391,487.23	859,557,878.73
9	Борлуулалт, маркетингийн зардал	51,374,497.19	90,010,406.90
10	Ерөнхий ба удирдлагын зардал	21,980,604,190.78	26,410,863,013.34
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	1,025,930,081.88	985,071,278.29
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	274,048.22	90,056.75
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(5,074,270.79)	(36,619,396.63)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(4,319,519,596.34)	250,370,228.99
19	Орлогын татварын зардал	32,700,213.29	112,789,299.68
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(4,352,219,809.63)	137,580,929.31
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(4,352,219,809.63)	137,580,929.31
27	Орлогын нийт дүн	(4,352,219,809.63)	137,580,929.31
28	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	103,120,842,001.77	113,244,795,826.66
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	102,787,583,899.59	112,983,288,097.70
1.1.2	Бусад мөнгөн орлого	333,258,102.18	261,507,728.96
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(95,242,269,664.37)	(104,963,142,677.96)
1.2.1	Ажиллагчдад төлсөн	(7,416,666,071.00)	(8,773,508,319.00)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(2,177,356,583.85)	(2,807,839,102.74)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	(967,126,200.70)	(722,981,865.90)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(1,612,908,586.56)	(1,599,159,708.98)
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	(2,801,947,652.13)	(3,148,814,086.83)
1.2.7	Бусад мөнгөн зарлага	(80,266,264,570.13)	(87,910,839,594.51)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,878,572,337.40	8,281,653,148.70
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,841,217.00	-
2.1.2	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	6,841,217.00	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(8,973,322,213.14)	(8,414,190,094.76)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(6,992,074,335.50)	(6,442,257,635.40)
2.2.2	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(1,981,247,877.64)	(1,971,932,459.36)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,966,480,996.14)	(8,414,190,094.76)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	357,267.58	111,167.16
3.1.1	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.2	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	357,267.38	111,167.16
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(119,426,360.36)	(20,782.81)
3.2.1	Төлсөн ногдол ашиг	(119,343,141.00)	-
3.2.2	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(83,219.36)	(20,782.81)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(119,069,092.78)	90,384.35
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,206,977,751.52)	(132,446,561.71)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,216,782,812.49	1,009,805,060.97
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,009,805,060.97	877,358,499.26

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	123,273,508,753.71	10,651,725,701.30	16,905,316,328.48	-	(1,358,866,633.22)	149,471,684,150.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	10,651,725,701.30	-	-	-	-	10,651,725,701.30
Залруулсан үлдэгдэл	133,925,234,455.01	10,651,725,701.30	16,905,316,328.48	-	(1,358,866,633.22)	160,123,409,851.57
Бусад дэлгэрэнгүй орлого	-	41,445,006,176.41	-	2,051,204,420.00	0.00	43,496,210,596.41
Өмчид гаргасан өөрчлөлт	(839,049,337.96)	(10,651,725,701.30)	-	-	(146,624,356.00)	(11,637,399,395.26)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(4,352,219,809.63)	(4,352,219,809.63)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	2,322,198,697.05	-	(18,584,303.79)	2,303,614,393.26
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	133,086,185,117.05	41,445,006,176.41	19,227,515,025.53	2,051,204,420.00	(5,876,295,102.64)	189,933,615,636.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	41,444,856,363.30	-	-	-	-	41,444,856,363.30
Залруулсан үлдэгдэл	174,531,041,480.35	41,445,006,176.41	19,227,515,025.53	2,051,204,420.00	(5,876,295,102.64)	231,378,471,999.65
Бусад дэлгэрэнгүй орлого	-	12,935,243,329.00	-	-	-	12,935,243,329.00
Өмчид гаргасан өөрчлөлт	-	(41,444,856,363.30)	-	-	-	(41,444,856,363.30)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	137,580,929.31	137,580,929.31
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	(417,391,788.50)	-	417,391,788.50	-
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	174,531,041,480.35	12,935,393,142.11	18,810,123,237.03	2,051,204,420.00	(5,321,322,384.83)	203,006,439,894.66

4.5 Зорилтот түвшин, түүний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
Нийт орлого	98,056,700,000.00	102,628,082,330.71	(4,571,382,330.71)	104.7
Борлуулалтын орлого	96,971,900,000.00	101,631,521,737.71	(4,659,621,737.71)	104.8
Бусад орлого	1,084,800,000.00	996,560,593.00	88,239,407.00	91.9
НИЙТ ЗАРДАЛ	104,895,359,998.00	102,377,712,127.00	2,517,647,871.00	97.6
Худалдаж авсан ДЭХүч	76,419,900,000.00	74,855,126,896.00	1,564,773,104.00	98.0
Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	10,392,672,741.00	10,369,030,216.00	23,642,525.00	99.8
Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	1,506,397,547.00	1,504,836,412.00	1,561,135.00	99.9
Гэрэл, цахилгаан	1,709,106,780.00	1,435,802,610.00	273,304,170.00	84.0
Түлш, халаалт	34,102,611.00	33,951,921.00	150,690.00	99.6
Цэвэр, бохир ус	14,675,247.00	9,187,220.00	5,488,027.00	62.6
Материал, хангамжийн зардал	54,805,801.00	33,622,020.00	21,183,781.00	61.3
Тээвэр, шатахуун	120,922,244.00	104,456,675.00	16,465,569.00	86.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,166,000.00	27,935,243.00	2,230,757.00	92.6
Контор, хангамжийн зардал	41,268,370.00	48,331,289.00	-7,062,919.00	117.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	211,030,282.00	176,422,625.00	34,607,657.00	83.6
Урсгал засвар	540,950,655.00	403,234,972.00	137,715,683.00	74.5
албан томилолт	42,980,700.00	42,536,782.00	443,918.00	99.0
Харуул хамгаалалт	71,592,480.00	69,576,751.00	2,015,729.00	97.2
Гүйцэтгэх удирдлагын зардал	544,325,502.00	471,546,226.00	72,779,276.00	86.6
Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	77,624,350.00	63,126,767.00	14,497,583.00	81.3
Борлуулалт, маркетингийн зардал	89,182,900.00	90,010,407.00	-827,507.00	100.9
Даатгалын үйлчилгээ	24,388,508.00	12,547,647.00	11,840,861.00	51.4
Диспетчерийн зардал	646,125,300.00	808,932,100.00	(162,806,800.00)	125.2
Зохицуулах үйлчилгээний хөлс	99,708,000.00	104,501,833.00	(4,793,833.00)	104.8
Гадны үйлчилгээний хөлс	81,922,670.00	56,378,709.00	25,543,961.00	68.8
Газрын төлбөр	19,434,475.00	19,434,475.00	-	100.0
Найдваргүй авлагын зардал	57,500,000.00	57,500,000.00	-	100.0
Элдэгдлийн зардал	9,774,813,020.00	9,694,774,950.00	80,038,070.00	99.2
Сургалтын зардал	68,868,800.00	57,251,539.00	11,617,261.00	83.1
Хүүгийн зардал-урт хугацаат зээл	166,647,200.00	152,865,072.00	13,782,128.00	91.7
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	99,377,915.00	88,609,110.00	10,768,805.00	89.2
Ажиллагсдын нийгмийн зардал	1,362,369,900.00	1,199,497,813.00	162,872,087.00	88.0
Валютын ханшны алдагдал		21,110.00	(21,110.00)	
Үйл ажиллагааны бус бусад зардал	592,500,000.00	386,662,737.00	205,837,263.00	65.3
НИЙТ АШИГ АЛДАГДАЛ	(6,838,659,998.00)	250,370,203.71	(6,588,289,794.29)	(3.7)
Татварын дараах ашиг, алдагдал	(4,352,219,810.00)	137,580,929.00	(4,214,638,881.00)	(3.2)
Ажиллагсадын тоо	374	384	(10)	
Удирдах ажилтан	5	5	0	
ИТА	139	151	(12)	
Ажилчид	225	224	1	
Гэрээт ажилтан	5	4	1	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.03.09	Аудитын нэр: “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2020/70/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Гүйцэтгэх захирлын 2019 оны 12-р сарын 31-ний Б/325 тоот тушаалаар нэр бүхий дөрвөн ажилтанд орон сууцны зээлд дэмжлэг үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор тооцсон 80,0 сая төгрөг, Гүйцэтгэх захирлын 2019 оны 12-р сарын 23-ний Б/317 тушаалаар нэр бүхий ажилтанд нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгохоор шийдвэрлэсэн 35.4 сая төгрөгийг тус тус өглөг дансанд бүртгэж тайлагнасан байна.	115.4	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	Г.Баярсайхан И.Шүрэнцэцэг
2	ТУЗ-ын 2018 онд "Компанийн 2018 оны их засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай" 34 дүгээр тогтоолоор албан хэрэгцээнд-1, шуурхай ажиллагааны бригадад-2 автомашин худалдан авахад 170.0 сая төгрөг батлагдсанаар 2019 оны 2 дугаар сард 3 ш автомашиныг 165.0 сая төгрөгөөр худалдан авсан байна	165.0	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	Г.Баярсайхан И.Шүрэнцэцэг
3	Тайлант оны биет бус хөрөнгийн тооллогын тооцоо бодсон актаар 23 нэр төрлийн 822.8 сая төгрөгийн хөрөнгөнөөс 2000 онд ашиглалтанд орсон “Зохиогчийн эрх барааны тэмдэг” 34.5 сая төгрөг, 2012 оны ашиглалтанд орсон “Бар кодын программ” 0.5 сая төгрөг, 2014 онд ашиглалтанд орсон “Цайны газрын удирдлагын программ” 1.5 сая төгрөг тус тус анхны өртгөө нөхсөн хэрэгцээ шаардлагагүй, ашиглалтгүй программ, биет бус хөрөнгийг данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	36.5	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	Г.Баярсайхан И.Шүрэнцэцэг

4	Тайлант онд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ТЗБАХ-2019/6 гэрээт ажлын төлбөр 29.9 сая төгрөг, Судалгааны ажлын гэрээгээр Зөвлөх үйлчилгээний ЗҮ-2019/04 ажлын санхүүжилт 49.0 сая төгрөг нийт 78.9 сая төгрөгийг үйл ажиллагааны бус зардлын дансанд бичиж тайлагнасан байна.	78.9	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	Г.Баярсайхан И.Шүрэнцэцэг
	ДҮН	395.8			

